



# ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ БИЧМЭЛ ТАЙЛАН

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАНИЛЦУУЛГА

### 1. Дотоодын нийт бүтээгдэхүүн

2022 онд дотоодын нийт бүтээгдэхүүн 1,426,3 сая төгрөг болж, 2021 оноос 223 сая төгрөг буюу 18,6 хувиар өсч, аймгийн нэг хүнд 13,7 сая төгрөгний дотоодын нийт бүтээгдэхүүн ноогдож байна.

### 5. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь

“Хоршоо хөгжүүлэн сан”-гийн 955 зээлдэгчийн мэдээллийг Монгол банкны мэдээллийн мэдээллийн санд оруулж, 137 зээлдэгчид 1247,0 сая төгрөг зээлийг олгож, шинээр 183 ажлын байр бий болж, өмнөх оныхоос зээлийн эргэн төлөлт 86,7 хувиар өсч, шинээр цэвэр усны үйлдвэр, худалдаа үйлчилгээний төв, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр үйлчилгээ байгуулахад нь дэмжлэг үзүүлсэн.

### 6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлтийн хувь

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн эргэн төлөлтийн хувь 2022 онд 67 хувьтай байна.

### 7. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь

Сэлэнгэ аймгийн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн хүн амд эзлэх хувь 98.0 байгааг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3 хувиар өссөн нь иргэд эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ 1 сар л төлөөгүй бол эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ авах боломжгүйгээс гадна бүх өрх, сум тосгоны эрүүл мэндийн төвийн үзүүлж байгаа тусlamж үйлчилгээнд эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн байдлыг шалгадаг болсон учир эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлсөн нь иргэдийн эзлэх хувь нэмэгдэх нөхцөл бүрдсэн байна.

### 8. Шинээр бий болсон ажлын байр

2022 онд шинээр 1220 ажлын байр бий болсныг 2021 онтой харьцуулахад 6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2021 онд “Ковид-19” цар тахалтай холбогдуулан аж ахуй нэгж байгууллагууд ажиллах боломж бага байсан бол 2022 онд аж ахуй нэгж байгууллагууд ажиллах боломж гарч, шинэ ажлын байрны тоо өсөхөд нөлөөлсөн.

### 9. Хэрэглээний үнийн индекс

Дэлхий нийтийг хамарсан “Ковид-19” цар тахал, ОХУ, Украян улс хоорондын дайнаас шалтгаалан өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оныхоос 13.6 хувиар өсөхөд тээвэр зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 22.4 хувь, бусад бараа, үйлчилгээ 18.7 хувь, хүнсний бараа, согтууруулах бус ундаа 16.9 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа 16.1 хувь, тээвэр, хувцас, бэс бараа, гутал, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ 13.7 хувь, эм, тариа, эмнэлэгийн үйлчилгээ 9.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш 8.6



## ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ БИЧМЭЛ ТАЙЛАН

хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис 7.7 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ 0.3 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

### 10. Малын тоон өсөлт

Аймгийн хэмжээнд 1.9 сая толгой мал байгаагаас 44.8 хувийг хонь, 32.7 хувийг ямаа, 15.6 хувийг үхэр, 6.7 хувийг адуу, 0,02 хувийг тэмээн сүрэг эзэлж байгаа бөгөөд өмнөх оныхоос 25.6 мянган толгой буюу 1.3 хувиар өсч, ямаа 1.3 хувиар буурсан байна. Цаашид аймгийн малын тоо толгойг тогтворжуулан, зохистой харьцаанд барин мал аж ахуйг бүсчлэн хөгжүүлж, малаас авах ашиг шим, чанарыг сайжруулах, эрчимжсэн суурин, хагас суурин аж ахуйг хөгжүүлэн мах, сүүний чиглэлийн боловсруулах үйлдвэр байгуулах, малын эрүүл мэндийг хамгаалан өвчлөлгүй тайван аймаг болж, эрүүл бүсийг байгуулан мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

### 11. Хураан авсан үр тариа

2022 онд үр тариа 136.9 мянган га талбайд тариалалт хийж, 183.9 мянган тн буюу 14 цн ургац хураан авсан. Үүнээс улаанбуудай 125.2 мянган га талбайгаас 177.8 мянган тн ургац 14,2 цн, арвай 682 га талбайгаас 748 тн, овьёос 4.8 мянган га талбайгаас 4.4 тн, гурвалжин будаа 945 га талбайгаас 823 тн, тэжээлийн ургамал 15.9 мянган га талбайгаас 27.9 тн, тосны ургамал 49.3 мянган га талбайгаас 23.5 тн ургац хураан авч, 9,5 мянган га талбайд усалгаатай талбайд тариалалт хийсэн.

### 12. Хураан авсан малын тэжээл

Аймгийн хэмжээнд 16.0 мянган га талбайгаас 27.9 мянган тн тэжээлийг хураан авч өмнөх оноос 18 хувиар нэмэгдэж, 10 сумын 21 малчинд 10 тн овьёосны үрийг дэмжлэг үзүүлж, 46.5 га талбайгаас 281 тн ногоон тэжээлийн сумын аюулгүйн нөөцийг бүрдүүлсэн.

### 13. Хураан авсан хүнсний ногоо

2.3 мянган га талбайгаас төмс 30.6 мянган тн, 3.5 мянган га талбайгаас хүнсний ногоо 52.7 мянган тн хураан авч, төмс 26.3 хувиар, хүнсний ногоо 46.6 хувиар тус тус нэмэгдсэн.

### 14. Хүлээн авах гадаад жуулчин

Аймгийн Алтанбулаг, Сүхбаатар боомтоор давхардсан тоогоор 274.2 мянган зорчигч нэвтэрсэн нь өмнөх оныхоос 17 хувиар өсөж, нийт зорчигчдын 175.7 мянга буюу 64.1 хувь нь Монгол иргэд, 98.5 мянга буюу 35.9 хувь нь гадаад иргэд хилээр нэвтэрч, өмнөх оныхоос Монгол иргэдийн тоо 12.5 хувиар, гадаад иргэдийн тоо 4.2 хувиар өссөн.

### 15. Идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага

Энэ онд бизнес регистрийн санд 4114 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 1768 буюу 43.0 хувь нь үйл ажиллагаа явуулж, Сүхбаатар, Мандал, Ерөө суманд 2345 буюу 57.0 хувь, Сайхан, Хүдэр, Баянгол, Цагааннуур, Алтанбулаг,



## ХЯАЛАТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ БИЧМЭЛ ТАЙЛАН

Шаамар суманд 1153 буюу 28.0 хувь, бусад сумдад 616 буюу 15.0 хувь нь үйл ажиллагаа явуулж байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн өмчийн хэлбэрээр нь авч үзвэл төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж 259, Монгол Улсын иргэний өмчийн 1496, гадаад улсын иргэнтэй хамтарсан 3, гадаад улсын иргэний өмчийн 10 аж ахуйн нэгж байна.

### **16. Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан нийт өрхөд эзлэх хувь**

Аймгийн нийт өрхийн 72.8 хувь нь байшинд, 25.8 хувь нь гэр амьдарч байгааг өмнөх оныхоос 0.2 пунктээр нэмэгдэж, байшинд амьдардаг өрхийн эзлэх хувь 0.2 пунктээр буурчээ. Орон сууцны байшинд суудаг өрхийн тоо нийт өрхийн 27.7 хувийг эзэлж, 2021 оныхоос 13.1 хувиар нэмэгджээ.

### **17. Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь**

Энэ онд халаалтын төвлөрсөн системд холбогдсон өрх 18.4 хувь, цахилгааны төвлөрсөн системд өрх 83.5 хувь, төвлөрсөн усан хангамжинд 17.3 хувь, бохир ус зайлцуулалтын төвлөрсөн системд өрх 16.7 хувь тус тус холбогдсон байна.

### **18. Жендерийн тэгш бус байдлын индекс**

Товлолт дархлаажуулалтын хамралт 99 хувьтай байгаа бөгөөд өмнөх оны түвшиннд байна.

### **19. Бүртгэгдсэн гэмт хэрэг**

Аймгийн хэмжээнд 2022 онд 775 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 138 хэргээр буюу 21.7 хувиар өссөн. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 222 бүртгэгдэж 34 буюу 18.0 хувиар өссөн.

### **20. Иргэдэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэлтийн түвшин**

Иргэдэд учирсан хохирлын нөхөн төлүүлэлтийн түвшин 42,0 хувь буюу өмнөх оны мөн үеэс 11.4 хувиар буурсан дүнтэй байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар учирсан хохирол 5.663.960,0 сая бөгөөд нөхөн төлүүлсэн хохирол өмнөх оны мөн үеэс 11.4 хувиар буурсан байна.

### **21. РМ 2,5 тоосонцорын жилийн дундаж агууламж**

Сүхбаатар сумын агаарын чанарын 1 дүгээр харуул, Мандал сумын Зүүнхараа агаарын чанарын 2 дугаар харуулын шинжилгээгээр 2022 онд агаарын чанарыг автомат багажаар тодорхойлоход 33 М кг/м3 байгаа нь агаарын чанарын ангиллаар хэвийн буюу стандартын шаардлага хангаж байна.

### **22. РМ10 тоосонцорын жилийн дундаж агууламж**

Агаарын чанарын шинжилгээгээр энэ онд РМ10 том ширхэглэг тоосонцорын жилийн дундаж агууламж 44 М кг/м3 байгаа нь өмнөх оноос 45 хувиар буурсан нь хэвийн буюу агаарын чанарын стандартын шаардлага хангаж байна.



## ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ БИЧМЭЛ ТАЙЛАН

### 23. Ойгоор бүрхэгдсэн талбай

Аймгийн хэмжээнд ойн сангийн талбай 1931.2 мянган га, үүнээс ойгоор бүрхэгдсэн талбай 1441.0 мянган га, байгалийн ой 1397.4 мянган га, ойгоор бүрхэгдээгүй ойн талбай 406.6 мянган га буюу 43,6 хувийг эзэлж байна.

### 27. Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь

2021 онд arterийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамрагдалт 44,4 хувь байсан бөгөөд 2022 онд өмнөх оны мөн үеэс 11,9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь анхан шатны эрүүл мэндийн байгууллага эрт илрүүлгийн ач холбогдлын талаарх сургалт сурталчилгааг эрчимжүүлснээр иргэдийн мэдлэг, хандлага сайжирч оношилгоо шинжилгээний хамрагдах идэвх нэмэгдсэн.

### 28. Чихрийн шижин хэв шинж-2 өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь

2021 онд чихрийн шижин хэв шинж-2 өвчний эрт илрүүлгийн хамрагдалт 39,4 хувь байсан бөгөөд 2022 онд өмнөх оны мөн үеэс 13,8 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь анхан шатны эрүүл мэндийн байгууллага эрт илрүүлгийн үзлэг, оношилгоо шинжилгээний ажлыг зохион байгуулсантай холбоотой.

### 29. Хорт хавдрын эрт илрүүлгийн хувь

2021 онд хорт хавдрын эрт илрүүлгийн хамрагдалт 37,2 хувь байсан бөгөөд 2022 онд өмнөх оны мөн үеэс 4,4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас иргэдэд урьдчилан сэргийлэх үзлэг, явцын хяналт, оношилгоо шинжилгээг хийснээр энэ тоон үзүүлэлт нэмэгдсэн байна.

### 30. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт хувь:/цэвэр жин/

2022-2023 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин 82.7%-тай байна. Үүнийг өнгөрсөн хичээлийн жил /82.5%/-ийнхтэй харьцуулахад 0.2% ахисан үзүүлэлттэй байгаа нь 2 настай хүүхдүүдийг 2021 онд цар тахлын улмаас цэцэрлэгт хүлээн аваагүй бөгөөд улмаар 2022 оны 02 дугаар сараас эхлэн БШУЯ-наас шийдвэр гарч, хамруулж эхэлсэнтэй холбоотойгоор сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлж байгаа хүүхдийн тоо өссөн байна.

### 31. Суурь боловсролын хамрагдалтын хувь: /цэвэр жин/

2022-2023 оны хичээлийн жилд төрийн өмчийн 35 сургуульд нийтдээ 21953 хүүхэд суралцаж, суурь боловсролын хамран сургалт 91.0 хувьд хүрч, өнгөрсөн жил /87.5/-ийнхтэй харьцуулахад 3.5 хувиар ахисан үзүүлэлттэй байна.

### 32. Цэцэрлэгийн бүлгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо

Цэцэрлэгийн бүлгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо 26.7 байгаа нь өмнөх оноос 0.5-аар өссөн. Энэ нь энэ хичээлийн жилийн хүүхдийн тоо болон бүлгийн багшийн тоо өмнөх оноос өссөнтэй холбоотой.



## ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ БИЧМЭЛ ТАЙЛАН

### 33. Бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо

Бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо 29.2 байгаа ба өмнөх он /29.4/-оос 0.2-оор буурсан байна. Энэ нь бага ангийн хүүхдийн тоо өмнөх оноос 56 хүүхдээр цөөрсөн, суралцагчдын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой байна.

### 34. Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо:

2022 оны Элсэлтийн ерөнхий шалгалтад 977 шалгуулагч хамрагдаж, ирц 93.94 хувьтай. Энэ жил монгол улсын түүх, англи хэл, нийгмийн тухай мэдлэг хичээлээр тус бүр 1 нийт 3 шалгуулагч 800 оноо авч, элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж өнгөрсөн жил /503.7/-ийнхээс 2.9 хувиар ахисан /506.6/ байна.

### Шинээр ашиглалтад оруулсан цэцэрлэг, сургуулийн тоо:

Ерөө суманд:

-Олон улсын стандартад нийцсэн 960 хүүхдийн багтаамжтай эко сургуулийг “Монголын Алт” компани нийгмийн хариуцлагын хүрээнд 11,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулан хүлээлгэн өгсөн нь төр хувийн хэвшлийн хамтарсан нэг том бүтээн байгуулалт боллоо. Тус сургуулийн барилга нь Монгол орны 330 сумдаас анхны орон нутагт баригдсан олон улсын стандартад нийцсэн сургууль болж байна.

-Улсын төсвийн 3 тэрбум 229.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 200 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн шинэ барилгыг ашиглалтад оруулснаар бүлэг дүүргэлт 25-д хүрч, 4 иргэнийг ажлын байраар хангаж, шинээр 2 бүлэг нэмэгдэж, эцэг эхчүүдийн ажил хөдөлмөр эрхлэх боломжийг нь бүрдүүллээ.

\_\_\_\_\_ооо\_\_\_\_\_

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН  
ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ**



## ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ БИЧМЭЛ ТАЙЛАН

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь үзүүлэлт		2022 оны зорилтолт түвшин	2022 оны гүйцэтгэл	Оноо	Хувь
			2021 он	2021 он				
<b>Эдийн засгийн үзүүлэлт</b>								
1	Дотоодын нийт бүтээгдэхүүн	Сая.т	1,202,6	822,814.7	1,426,3	5	100	
2	Нэг хүнд тоогоход дотоодын нийт бүтээгдэхүүн	Сая.т	11,9	7596.7	13,7	5	100	
3	Төсвийн зардал	Сая.т	100669.8	99078.1	67899.5	5	100	
4	Төсвийн тэнцэл		17101.7	0	19648	5	100	
5	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь	Хувь	88	88	86,7	4.9	98.5	
6	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлтийн хувь	Хувь	69.0	67.0	67.0	5	100	
7	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь	Хувь	-	90	98	5	100	
8	Шинээр бий болсон ажлын байрны тоо	Тоо	1105	1000	1220	5	100	
9	Хэрэглээний үнийн индекс	Индекс	16.1	3.2	13.6	5	100	
10	Малын тоо	Мянган толгой	1 886 735	1462489	1 912 300	5	100	
11	Хураан авсан үр тария	Мянган тонн	207,4	179.0	183.9	5	90.1	
12	Хураан авсан малын тэжээл бусад	Мянган тонн	30.5	18.0	27.0	5	100	
13	Хураан авсан хүнсний ногоо	Мянган тонн	36.5	34.0	46.6	5	100	
14	Хүлээн авах гадаад жуулчдын тоо	Тоо	23 387	1000	75 100	5	100	
15	Идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын тоо	Тоо	2447	2500	1768	3.5	70.7	
16	Инженерийн бүрэн хангамжтай орон	Хувь	30,1	35	32	4.5	91.4	



## ХЯАЛАТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ БИЧМЭЛ ТАЙЛАН

	сууцаар хангагдсан нийт өрхөд эзлэх хувь						
17	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь	Хувь	86	88	87	4.9	98.8
<b>Нийгмийн хөгжлийн үзүүлэлт</b>							
18	Жендерийн тэгш бус байдлын индекс	Индекс	0.29	0.31	0.313	5	100
19	Бүртгэгдсэн гэмт хэрэг	Тоо	557	557	775	3.5	71.8
20	Иргэдэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэлтийн түвшин	Хувь	53,6	56.1	42.0	3.7	74.8
21	PM 2,5 тоосонцорын жилийн дундаж агууламж	М кг/м3	37	35	33,0	4.7	94.2
22	PM10 тоосонцорын жилийн дундаж агууламж	М кг/м3	79	80	44,0	2.7	55
23	Ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь	Хувь	43,6	43.644	43,6	5	100
24	1 000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин	Промиль	8.5	5.8	9.8	2.9	59.1
25	10 000 хүн амд Вируст гепатитын өвчлөл	Тоо	0	2	0	5	100
26	Тухайн жилийн товлолт дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	Хувь	-	99.2	90	4.5	90.9
27	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь	Хувь	44.4	99.2	56.3	2.8	56.7
28	Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь	Хувь	39.4	89	53.2	2.9	59.7
29	Хорт хавдрын эрт илрүүлгийн үе	Хувь	37.2	56.0	41.6	3.7	74.2
30	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин	Хувь	82.7	83.0	82.5	4.9	92.3



## ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ БИЧМЭЛ ТАЙЛАН

31	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин	Хувь	91.3	87.6	91.0	5	100
32	Цэцэрлэгийн бүлгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	Toо	26.6	26.0	26.7	4.8	97.3
33	Бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	Toо	29.4	29.0	29.2	4.9	99.3
34	Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо	Toо	503.7	499.0	506.6	5	100
35	Төрийн цахим үйлчилгээний тоо	тоо	184	184	269	5	100

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР